

## **31-Р Дүүргийн хоолны хөтөлбөрийн талаарх асуулт, хариулт FAQ \* 2020 оны 10-р сараас 12-р сар хүртэл**

### **Бид яагаад энэ хөтөлбөрийн хэрэгжүүлж байгаа вэ?**

Зуны хүнсний хөтөлбөр, SFSP, нь Америкийн Хөдөө Аж Ахуйн Газраас (USDA) хэрэгжүүлдэг ашгийн бус, нийтийн болон хувийн бүх албан байгууллагуудтай нээлттэй хамтран ажилладаг хамгийн сайн шим тэжээллэг хүнсээр үйлчилдэг хөтөлбөр юм. Энэ хөтөлбөр нь сургуулийн зуны амралтын саруудад хүүхдүүдэд шим тэжээллэг хоол хүнсний тараах ажлыг зохион байгуулдаг ч энэ жил Ковид-19-тай холбогдуулан орон даяар сургуулиудтай хамтран ажиллаж эхлэж байна.

Энэхүү хөтөлбөр Ковид-19-тай холбогдуулан 12-р сарын 31-ний өдрийг хүртэл үргэлжилнэ.

Сургуулийн дүүргүүд энэхүү хөтөлбөртэй хамтран Ковид-19-д нэрвэгдсэн олон нийтэдтуслан ажиллана.

### **Дүүргээс ямар зардал гарах вэ?**

Энэхүү хөтөлбөрт хамрагдах нь дүүргүүдийн хувьд ашигтай. Хоолны үйлчилгээг үзүүлэхэд ажилчдын зардал болон бусад холбогдох зардлууд гардаг. Ковидоос шалтгаалан сургуульд ирэх сурагчдын тоо багассан нь хоолны үйлчилгээний орлогыг муудахад нөлөөлсөн. Улсаас хүүхэд тус бүрээр тооцон нэг хоолонд \$4.08 төлөх ба энэ нь бидний зардалаа нөхөхөд дэмжлэг болох юм.

### **Манай дүүргээс илүү их тусламж хэрэгтэй дүүргүүд байгаа эсэх?**

Энэ хөтөлбөрт хамрагдсанаар бид бусдын хэрэглэж болон нөөцөөс огтхон ч аваагүй болно. Бүх сургуулиудад зориулан төсөв батлагдсан гэсэн үг юм. Хүүхэд сайн сурч боловсрохын тулд шим тэжээллэг хоол хүнс идэх хэрэгтэй бай SFSP нь аль болох олон хүүхдийг хүнсээр хангах зорилготой.

### **Бид бүх гэр бүлүүдийг хамруулах уу? Яагаад зөвхөн тусламж хэрэгтэй өрхүүдэд туслаж болохгүй гэж?**

Ковид-19-т нэрвэгдээгүй олон нийт гэж байхгүй. Энэ цар тахалаас шалтгаалан олон гэр бүлүүд ажилгүй болж, олон янзаар хүндрэлтэй тулгарсан. Мөн зарим гэр бүлүүд гэрээсээ ажиллан, хүүхдүүдээ алсын зайнаас сургах, тэднийг шим тэжээллэг хоолоор хооллох зэрэг асуудалтай тулгарч байгаа. Бид бүх гэр бүлүүдэд ижилхэн хандаж, туслахыг хүсч байна. Бүх олон нийтэд энэ цаг үед тусламж хэрэгтэй.

## **31-Р Дүүргийн хоолны хөтөлбөрийн талаарх асуулт, хариулт FAQ \* 2020 оны 10-р сараас 12-р сар хүртэл**

### **Бид өдрийн хоолны захиалга хийх шаардлагатай юу?**

Үгүй. Бид өдрийн хоолны захиалга Google form-р авахгүй болсон. Бид танхимийн сургалтанд хамрагдаж байгаа бүх хүүхүүдэд хоолоор үйлчилнэ.

### **Хэрвээ бид ямар нэг хоолны харшилтай болон тусгай дэглэм барьдаг бол яах вэ?**

Та шим тэжээлийн талаарх мэдээллийн эндээс [FDmealplanner](#) (please see Field or Winkelman to view your meals) авна уу. Мөн цэсэн дээр бүх мэдээлэл өгөгдсөн байгаа. Бид аль болох тусгай шаардлагыг хангасан хоолоор үйлчлэх ба хэрвээ та ийм шаардлагатай байгаа бол дараах анкетийн бөглөнө [Хоолны дэглэмийн хүсэлт](#) (эндээс асуулт хариулттай танилцана уу). Бид газрын самар болон бусад самрын төрлийг гал тогоондоо хэрэглэдэггүй. Гэхдээ та манайхаас авсан хүнсний орцын мэдээллийг давхар шалгаарай. Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгч нар мэдэгдэлгүйгээр орцын бүтцийг өөрчлөх магадлал байдаг тул та бүхэн шалгах хэрэгтэй. Хэрвээ таньд ямар нэг асуулт байвал [garellano@questfms.com](mailto:garellano@questfms.com) хаягаар холбогдоно уу.

### **Бид яагаад гэр бүлүүдээс хамрагдахгүй байх хүсэлтэй байгааг асууж байгаа вэ?**

Зарим гэр бүлүүд уг хөтөлбөрт хамрагдахгүй байх олон янзын шалтгаантай байгааг бид ойлгож байна. Хоолны үлдэгдэл гаргахгүй байх үүднээс бид тэдгээр гэр бүлүүдээс тэдний хүсэлтийг асууж байна. **Хэрвээ та энэ жил сургуулиас хүнс авах хүсэлгүй байгаа бол Griselda Arellano-д [garellano@questfms.com](mailto:garellano@questfms.com) хаягаар мэдэгдэнэ үү.**

### **Хөтөлбөрөөс нэрээ хасуулсан ч дараа нь дахин авах хүсэлт гаргаж болох уу?**

Тийм. Бид зөвхөн төлөвлөлт хийхийн тулд таниас таны саналын асууж байгаа юм. Иймд та хөтөлбөрт эргэн хамрагдах хүсэлтээ гаргах боломжтой.

### **Хөтөлбөрт өдөр бүх хамрагдах ёстой юу? Мана хүүхэд зарим хоолыг нь идээд заримыг нь идэхгүй.**

Хэртээ та хөтөлбөрт тогтмол хамрагдахыг хүсэхгүй байгаа бол та нэрээ хасуулахын санал болгоно. Энэ нь зөвхөн тоо баримжаа авах зорилготой бүртгэл

## **31-Р Дүүргийн хоолны хөтөлбөрийн талаарх асуулт, хариулт FAQ \* 2020 оны 10-р сараас 12-р сар хүртэл**

юм. Хэдийгээр та хүүхэддээ хоол өгч явуулахаа мартсан бол танай хүүхдэд тухайн өдөр хоолоор үйлчилнэ.

Хэрвээ та гэрээсээ өдрийн хоол явуулж болно. Бид сурагчдын ирц болон хэрэглээг харан хоолоо бэлтгэнэ. Энэ нь бидэнд хаягдал хүнсийг аль болох бага байлгахад туслана.

### **Идээгүй хоолоо ямар нэг байдлаар хандивлах боломж байгаа эсэх?**

Үгүй. Хүнсний аюулгүй байдлын үүднээс хүнсийг нэг хэмд хүрсэний дараа дахин хэрэглэх боломжгүй юм. Бид өдөр ирэх тусам туршлагажин хаягдал гаргахгүй байх талаас ажиллана.

### **Энэ хөтөлбөр 12-р сарын 31-ээс хойш сунгагдах эсэх?**

Улсаас үг хөтөлбөрийг энэ жил 2 удаа сунгасан. Дахин сунгагдах эсэхийг бид мэдэхгүй байна.

### **Бид үнэгүй хоол авахын тулд орлогын шаардлага хангах шаардлагатй юу?**

Үгүй. SFSP-ийн энэ хөтөлбөр нь бүх хүүхдүүдэд зориулсан Ковид-19-ийн үеэр гэр бүлүүдийг дэмжих хөтөлбөр юм.

### **Манай хүүхэд заавал 31-р дүүрэгт сурдаг байх ёстой юу?**

Үгүй. SFSP-ийн энэ хөтөлбөр нь 18 хүртлэх насны бүх хүүхдүүдэд зориулсан Ковид-19-ийн үеэр гэр бүлүүдийг дэмжих хөтөлбөр юм.

### **Өөр хаяг дээрээс очиж авч болох уу?**

Өөр дүүргүүд хамрагдаж байгаа ч та нэгээн илүү давхардаж хүнс авах боломжгүй юм. You may NOT receive free meals from more than one local agency at the same time (1 хүүхэд 1 долоо хоногт 7 хоногийн хүнс авах ёстой)

### **Алсын зайн сургалтын талаарх асуулт**

**Бид бүтэн алсын зайн сургалтанд хамрагдаж байгаа болон хөтөлбөрөөс хасагдах уу?**

## **31-Р Дүүргийн хоолны хөтөлбөрийн талаарх асуулт, хариулт FAQ \* 2020 оны 10-р сараас 12-р сар хүртэл**

Үгүй. Алсын зайнаас суралцаж байгаа сурагчид хөлдөөсөн хоолыг жимс, ногоо, сүүний хамт авах боломжтой. Бид хүнсээ нарийн төлөвлөх тул хүнсний илүүдэл гаргахгүйгээр ажиллахыг хичээнэ. Хэрвээ та хүнсээ гэрийн хаягаараа хүргүүлэхийг хүсвэл доорх анкетийг бөглөнө үү.

### **Хөлдөөсөн хоол нь өдрийн цэснээс өөр байх уу?**

Хөлдөөсөн хоол нь өдрийн хоолны цэстэй ижил байна (халаах зааварчилгаатай). Үндсэн хүнс нь хэрэгцээнээс шалтгаалан өөрчлөгдөж болох ч дагалдан ирэх хүнс нь цэсийн дагуу байх болно.

### **Хэдэн хүнс хүлээн авах вэ?**

Та Даваа гараг бүр Glenbrook South Ахлах сургууль дээрээс 7 өглөөний хоол, өдрийн хоол хүлээн авна. Та бүхэн хүнсээ хүргүүлэх хүсэлтэй байгаа бол North Shore Transit-р таньд хүргэж өгч үйлчилнэ.

### **Яагаад очиж авах цаг нь Даваа гарагт 8:30– 12 хооронд вэ?**

Бид ажиллаж байгаа эцэг эхүүдэд тохиромжтой байлгах үүднээс энэ цагийн хуваариар түгээнэ. Энэ цаг нь ажиллаж байгаа эцэг эхчүүд болон манай ажилчдын ажлын цагт тааруулж байгаа юм. Бид цагийн хуваариа өөрчлөх болбол та бүхэнд цаг тухайд нь мэдэгдэх болно.

### **Хүнс хаанаас хүлээн авах вэ?**

Glenbrook South Ахлах Сургууль (Н хаалга).

### **Хэрвээ хүнсээ гэртээ хүргүүлэх хэрэгтэй бол яаж зохицуулах вэ?**

Та дараах анкетаас өөрт тохирохыг бөглөнө үү. 31-р дүүрэг Quest болон First Student автобус компанитай хамтран Даваа гараг бүр гэрт тань хүргэлт хийнэ.

[Хоол хүргүүлэн авах хүсэлт гаргах – Англи](#)

[Хоол хүргүүлэн авах хүсэлт гаргах - Испани](#)

[Хоол хүргүүлэн авах хүсэлт гаргах - Монгол](#)

[Хоол хүргүүлэн авах хүсэлт гаргах - Солонгос](#)

## **31-Р Дүүргийн хоолны хөтөлбөрийн талаарх асуулт, хариулт FAQ \* 2020 оны 10-р сараас 12-р сар хүртэл**

**20) Ковид-19-тай холбогдуулан ямар аюулгүй байдлын арга хэмжээ авч байна вэ?**

Сурагчид тусгай зориулалтын халхавчны ард суун хоолоо иднэ. Бид сурагчиддаа хоолоо халуунаар хурдан түгээхийн тулд яг ижил хоолоор үйлчилнэ.